



**ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ,
ЭСХҮЛ ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН
ЭДЛЭЛИЙН АРИЛЖАА
ЭРХЛЭГЧДИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ
ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

Үл хөдлөх хөрөнгө зуучлал, үнэт эдлэлийн зохицуулалтын газар

Улаанбаатар хот
2025 он



АГУУЛГА

1

САЛБАРЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

2

АРИЛЖААНЫ МЭДЭЭ

3

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН
ҮЗҮҮЛЭЛТ**

4

БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИН

5

ДУГНЭЛТ



Товчилсон үгийн тайлал

1. Хороо-Санхүүгийн зохицуулах хороо
2. ҮМҮЧЭТХЭАЭ-Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч
3. АНУ - Америкийн Нэгдсэн Улс
4. ХБНГУ - Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
5. БНИУ - Бүгд Найрамдах Ирланд Улс
6. ХЭ - Хувьцаа эзэмшигч
7. ХНХ - Хувь нийлүүлсэн хөрөнгө
8. ГХО - Гадаадын хөрөнгө оруулалт



Хүснэгт, дүрслэлийн жагсаалт

Хүснэгт 1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч иргэн, хуулийн этгээдийн байршил

Хүснэгт 2. Санхүүгийн тайлангийн үзүүлэлт

Хүснэгт 3. Орлогын тайлангийн үзүүлэлт

Дүрслэл 1. Тусгай зөвшөөрөлтэй этгээдийн тоо

Дүрслэл 2. Хүсэлт шийдвэрлэлт

Дүрслэл 3. Арилжаа эрхлэгчид байршлаар

Дүрслэл 4. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ

Дүрслэл 5. Хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтэц

Дүрслэл 6. ГХО-ын дэлгэрэнгүй

Дүрслэл 7. Хувьцаа эзэмшигчдийн бүтэц

Дүрслэл 8. Үнэт металлын борлуулалтын хэмжээ

Дүрслэл 9. Алтны борлуулалтын хэмжээ

Дүрслэл 10. Мөнгөний борлуулалтын хэмжээ


Дүрслэл 11. Үнэт эдлэлийн борлуулалтын үнийн дүн



Хураангуй

- ◆ Энэ оны эхний хагас жилийн байдлаар Хороонд үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй нэр 56 хуулийн этгээд, 492 иргэн бүртгэгдсэн байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн тоо 3-аар, иргэдийн тоо 39-өөр өссөн үзүүлэлт юм.
- ◆ Тайлант хугацаанд тусгай зөвшөөрөлтэй үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчид салбар нээн ажиллуулах тухай 1, хаяг байршлын өөрчлөлтийг бүртгүүлэх тухай 1 хүсэлт тус тус Хороонд ирүүлснийг холбогдох хууль тогтоомжийн дагуу хянаж, шийдвэрлэлээ.
- ◆ Тайлант хугацааны байдлаар ҮМҮЧЭТХЭАЭ 56 хуулийн этгээд нь 88 хувьцаа эзэмшигчийн 10,214,429.1 мянган төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаа эрхэлсэн байна. Хувь нийлүүлсэн хөрөнгийн 55.4 хувийг дотоодын хөрөнгө оруулалт эзэлж байгаа бол 44.6 хувийг гадаадын хөрөнгө оруулалт эзэлж байна.
- ◆ Тайлант хугацаанд ҮМҮЧЭТХЭА эрхлэгчид 860.9 кг үнэт металлыг 123,838,511.5 мянган төгрөгөөр худалдан авч, 506.4 кг үнэт металлыг 140,636,395.0 мянган төгрөгөөр худалдан борлуулсан байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад худалдан авсан үнэт металлын хэмжээ 1.1 дахин, худалдсан үнэт металлын хэмжээ 1.3 дахин буурсан үзүүлэлтэй байна.
- ◆ ҮМҮЧЭТХЭА эрхлэгчид 2025 оны эхний хагас жилд 348.8 кг алтыг 121,615,848.9 мянган төгрөгөөр худалдан авсан нь өмнөх оны мөн үеэс худалдан авсан алтны хэмжээ 1.8 дахин, үнийн дүн 1.2 дахин буурсан бол 384.7 кг алтыг 137,546,181.3 мянган төгрөгөөр худалдан борлуулсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад худалдсан алтны хэмжээ 1.5 дахин, үнийн дүн 1.0 дахин буурсан үзүүлэлт юм.
- ◆ Тайлант хугацаанд ҮМҮЧЭТХЭА эрхлэгчид нь нийт 269.3 кг мөнгийг 2,059,081.0 мянган төгрөгөөр худалдан авч, 121.4 кг мөнгийг 3,008,484.5 мянган төгрөгөөр худалдан борлуулсан бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад худалдан авсан мөнгөний хэмжээ 1.2 дахин буурсан бол худалдан борлуулсан мөнгөний хэмжээ 1.8 дахин өссөн үзүүлэлтэй байна.
- ◆ Тайлант хугацаанд ҮМҮЧЭТХЭАЭ этгээдүүд 16,571,215.5 мянган төгрөгийн үнэт эдлэл худалдан авсан бөгөөд 30,713,643.7 мянган төгрөгийн үнэт эдлэлийг худалдан борлуулсан байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс худалдан авсан үнэт эдлэлийн үнийн дүн 1.4 дахин, худалдан борлуулсан үнэт эдлэлийн 1.5 дахин өссөн үзүүлэлт юм.
- ◆ Тайлант хугацаанд нэр бүхий 56 хуулийн этгээд нь 34,623,266.7 мянган төгрөгийн нийт орлоготой, 29,901,798.9 мянган төгрөгийн нийт зардалтайгаар үйл ажиллагаа эрхэлсэн байна.
- ◆ Мөн ҮМҮЧЭТХЭАЭ хуулийн этгээдүүд нь 4,721,467.8 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажилласан нь өмнөх оны мөн үеэс 1.6 дахин буурсан үзүүлэлт юм.
- ◆ ҮМҮЧЭТХЭАЭ хуулийн этгээдүүдийн нийт орлогын 98.3 хувийг борлуулалтын орлого эзэлж байна.
- ◆ Тайлант хугацаанд нэр бүхий 17 хуулийн этгээдэд тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх мэдэгдэл, 38 хуулийн этгээдэд тайлангийн хариу, нийт 55 этгээдэд холбогдох хариу хүргүүлээ.

Тайлант хугацааны байдлаар Хороонд үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй нэр 56 хуулийн этгээд, 492 иргэн бүртгэгдсэн байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн тоо 3-аар, иргэдийн тоо 39-өөр өссөн үзүүлэлт юм.



Дүрслэл 1. Тусгай зөвшөөрөлтэй этгээдийн тоо

Тайлант хугацаанд тусгай зөвшөөрөлтэй үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчид салбар нээн ажиллуулах тухай 1, хаяг байршлын өөрчлөлтийг бүртгүүлэх тухай 1 хүсэлт тус тус Хороонд ирүүлснийг холбогдох хууль тогтоомжийн дагуу хянаж, шийдвэрлэсэн. Эдгээр хүсэлтийг төрлөөр нь ангилан дүрслэл 2-т үзүүлэв.



1

САЛБАР



1

Хаяг байршил

Дүрслэл 2. Хүсэлт шийдвэрлэлт

Тусгай зөвшөөрөлтэй арилжаа эрхлэгч иргэдийн 73.2 хувь буюу 360 нь Улаанбаатар хотод, 26.8 хувь буюу 132 иргэн орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байна. Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч иргэн, хуулийн этгээдүүдийг байршлаар ангилбал:

Дүүрэг	Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч иргэд	Үнэт металл, үнэт чулуугаар хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч иргэд	Үнэт металл, үнэт чулууны, арилжаа эрхлэгч иргэд	Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч хуулийн этгээд
Сүхбаатар	5	7	4	14
Хан-Уул	3	8	1	13
Баянзүрх	6	7	8	3
Чингэлтэй	71	164	29	17
Баянгол	13	17	2	6
Сонгинохайрхан	5	9	1	2
Орон нутаг	53	7	72	1


Хүснэгт 1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч иргэн, хуулийн этгээдийн байршил

Орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй 132 иргэний 71.2 хувь буюу 94 нь Баянхонгор, Өмнөговь, Сэлэнгэ, Дархан-Уул, Төв аймагт үйл ажиллагаа эрхэлж байгаа бол 28.8 хувь буюу 38 нь Увс, Баян-Өлгий, Ховд, Өвөрхангай, Дорноговь, Дорнод, Хэнтий, Говьсүмбэр, Говь-Алтай, Орхон, Архангай аймгуудад тархан байршжээ. Мөн тусгай зөвшөөрөлтэй 56 хуулийн этгээдийн 1 нь Баянхонгор аймагт үйл ажиллагаа эрхэлж байна. Арилжаа эрхлэгчдийн үйл ажиллагаа эрхэлж буй байршлын дэлгэрэнгүйг дүрслэл 3-т үзүүлэв.



Дүрслэл 3. Арилжаа эрхлэгчид байршлаар

Тайлант хугацааны байдлаар ҮМҮЧЭТХЭАЭ 56 хуулийн этгээд нь 88 хувьцаа эзэмшигчийн 10,214,429.1 мянган төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаа эрхэлсэн байна. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өмнөх оны мөн үетэй харьцуулан дүрслэл 4-д үзүүлэв.



Дүрслэл 4. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ (мянган төгрөгөөр)

Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч хуулийн этгээдүүдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 55.4 хувийг дотоодын хөрөнгө оруулалт эзэлж байгаа бол 44.6 хувийг гадаадын хөрөнгө оруулалт эзэлж байна. Хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтцийг дүрслэл 5-д үзүүлэв.




Дүрслэл 5. Хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтэц

Тайлант хугацаанд хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд дотоодын болон гадаадын хөрөнгө оруулалтын эзэлж буй хувийг өмнөх оны мөн үетэй харьцуулан дүрслэл 6-д үзүүлэв.

	2024.И	2025.И
БНСУ	79.8%	82.1%
АНУ	7.1%	5.5%
ЯПОН	6.8%	6.9%
ХБНГУ	5.3%	5.5%
БНИУ	1.0%	-

Дүрслэл 6. ГХО-ын дэлгэрэнгүй




Дүрслэл 7. Хувьцаа эзэмшигчид

Тусгай зөвшөөрөлтэй 56 хуулийн этгээдийн 35 нь 1 хувьцаа эзэмшигчтэй, 15 нь 2 хувьцаа эзэмшигчтэй, 6 нь 3 буюу түүнээс дээш хувьцаа эзэмшигчтэйгээр үйл ажиллагаа эрхэлж байна. Тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдүүдийг хувьцаа эзэмшигчдийн тоогоор нь ангилан дүрслэл 7-д үзүүлэв.

Арилжааны мэдээ тойм

Тайлант хугацаанд ҮМҮЧЭТХЭА эрхлэгчид 860.9 кг үнэт металлыг 123,838,511.5 мянган төгрөгөөр худалдан авч, 506.4 кг үнэт металлыг 140,636,395.0 мянган төгрөгөөр худалдан борлуулсан байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад худалдан авсан үнэт металлын хэмжээ 1.1 дахин, худалдсан үнэт металлын хэмжээ 1.3 дахин буурсан үзүүлэлтэй байна. Үнэт металлын борлуулалтыг дүрслэл 8-д үзүүлэв.



Дүрслэл 8. Үнэт металлын борлуулалтын хэмжээ

ҮМҮЧЭТХЭА эрхлэгчид 2025 оны эхний хагас жилд 348.8 кг алтыг 121,615,848.9 мянган төгрөгөөр худалдан авсан нь өмнөх оны мөн үеэс худалдан авсан алтны хэмжээ 1.8 дахин, үнийн дүн 1.2 дахин буурсан бол 384.7 кг алтыг 137,546,181.3 мянган төгрөгөөр худалдан борлуулсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад худалдсан алтны хэмжээ 1.5 дахин, үнийн дүн 1.0 дахин буурсан үзүүлэлт юм. Алтны борлуулалтын хэмжээг дүрслэл 9-д үзүүлэв.




Дүрслэл 9. Алтны борлуулалтын хэмжээ

Тайлант хугацаанд ҮМҮЧЭТХЭА эрхлэгчид нь нийт 269.3 кг мөнгөйг 2,059,081.0 мянган төгрөгөөр худалдан авч, 121.4 кг мөнгөйг 3,008,484.5 мянган төгрөгөөр худалдан борлуулсан бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад худалдан авсан мөнгөний хэмжээ 1.2 дахин буурсан бол худалдан борлуулсан мөнгөний хэмжээ 1.8 дахин өссөн үзүүлэлтэй байна. Мөнгөний борлуулалтын мэдээг дүрслэл 10-д үзүүлэв.



Дүрслэл 10. Мөнгөний борлуулалтын хэмжээ

Үнэт эдлэлийн борлуулалтын тойм



Дүрслэл 11. Үнэт эдлэлийн борлуулалтын үнийн дүн (мянган төгрөг)

Тайлант хугацаанд ҮМҮЧЭТХЭАЭ этгээдүүд 16,571,215.5 мянган төгрөгийн үнэт эдлэл худалдан авсан бөгөөд 30,713,643.7 мянган төгрөгийн үнэт эдлэлийг худалдан борлуулсан байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс худалдан авсан үнэт эдлэлийн үнийн дүн 1.4 дахин, худалдан борлуулсан үнэт эдлэлийн 1.5 дахин өссөн үзүүлэлт юм.

Мянган төгрөгөөр


ҮЗҮҮЛЭЛТ	2024.II	Нийт хөрөнгөд ЭЗЛЭХ ХУВЬ	2025.II	Нийт хөрөнгөд ЭЗЛЭХ ХУВЬ
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	17,557,572.0	23.5%	11,874,345.3	13.6%
Дансны авлага	3,233,191.4	4.3%	6,088,587.3	7.0%
Татвар, НДШ – ийн авлага	403,413.0	0.5%	683,285.0	0.8%
Бусад авлага	1,016,009.3	1.4%	3,424,375.3	3.9%
Бусад санхүүгийн хөрөнгө	-	-	2,049,291.5	2.3%
Бараа материал	31,541,395.9	42.1%	34,985,833.5	40.0%
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	6,703,993.8	9.0%	15,145,790.9	17.3%
Бусад эргэлтийн хөрөнгө	451,245.6	0.6%	41,142.1	0.0%
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	1,756,445.3	2.3%	1,550.0	0.0%
Эргэлтийн хөрөнгийн дүн	62,663,266.2	83.7%	74,294,200.9	84.9%
Үндсэн хөрөнгө	11,230,070.5	15.0%	11,624,099.7	13.3%
Биет бус хөрөнгө	533,584.0	0.7%	1,162,989.4	1.3%
Биологийн хөрөнгө			5,190.0	0.0%
Урт хугацаат хөрөнгө оруулалт	407,374.1	0.5%	408,604.1	0.5%
Хайгуул ба үнэлгээний хөрөнгө			790.0	0.0%
Хойшлогдсон татварын хөрөнгө	34,450.1	0.1%	29,015.8	0.0%
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө			1,406.0	0.0%
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	12,205,478.7	16.3%	13,232,095.1	15.1%
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	74,868,745.0	100.0%	87,526,296.0	100.0%
Дансны өглөг	17,721,476.5	23.7%	18,485,305.3	21.1%
Цалин, татвар, НДШ-ийн өглөг	1,894,896.4	2.5%	3,277,845.4	3.7%
Банкны богино хугацаат зээл	2,537,386.1	3.4%	4,251,663.6	4.9%
Хүүний өглөг	889,225.0	1.2%	1,098,100.7	1.3%
Ногдол ашгийн өглөг	202,500.0	0.3%	-	0.0%
Урьдчилж орсон орлого	5,506,543.1	7.4%	6,824,091.7	7.8%
Нөөц /өр төлбөр/	16,307.7	0.0%	15,654.1	0.0%
Бусад богино хугацаат өр төлбөр	7,027,472.9	9.4%	6,261,795.3	7.2%
Борлуулах зорилгоор эзэмшиж буй бүлэг хөрөнгөнд хамаарах өр төлбөр			885,486.6	1.0%
Богино хугацаат өр төлбөрийн дүн	35,795,807.8	47.8%	41,099,942.7	47.0%
Урт хугацаат зээл	6,821,229.6	9.1%	9,556,445.6	10.9%
Хойшлогдсон татварын өр	33,761.1	0.0%	7,573.6	0.0%
Бусад урт хугацаат өр төлбөр	-	-	214,174.3	0.2%
Урт хугацаат өр төлбөрийн дүн	6,854,990.7	9.1%	9,778,193.5	11.1%
Өр төлбөрийн нийт дүн	42,650,798.5	57.0%	50,878,136.2	58.1%
Өмч	10,063,429.1	13.4%	10,214,429.1	11.7%
- хувийн	10,063,429.1	13.4%	10,214,429.1	11.7%
Халаасны хувьцаа	2,278,232.1	3.0%	(168,000.0)	-0.2%
Нэмж төлөгдсөн капитал	-	-	2,278,232.1	2.6%

ҮЗҮҮЛЭЛТ	2024.II	Нийт хөрөнгөд эзлэх хувь	2025.II	Нийт хөрөнгөд эзлэх хувь
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	288,263.8	0.4%	864,381.7	1.0%
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц			-	0.0%
Эздийн өмчийн бусад хэсэг	1,105,664.6	1.5%	1,444,029.60	1.6%
Хуримтлагдсан ашиг	18,482,357.0	24.7%	21,679,087.4	24.8%
Эздийн өмчийн дүн	32,217,946.5	43.0%	36,648,159.8	41.9%
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	74,868,745.0	100.0%	87,526,296.0	100.0%

Хүснэгт 2. Санхүүгийн тайлангийн үзүүлэлт


Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн салбарын 2024 оны эхний хагас жилийн тайлангийн нэгтгэлд 53 хуулийн этгээд хамрагдсан бөгөөд 85 хувьцаа эзэмшигчийн 10,063,429.1 мянган төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй, 74,868,745.0 мянган төгрөгийн нийт хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаа эрхэлсэн байна.

2024.II



Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн салбарын 2025 оны эхний хагас жилийн тайлангийн нэгтгэлд 56 хуулийн этгээд хамрагдсан бөгөөд 88 хувьцаа эзэмшигчийн 10,214,429.1 мянган төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй, 87,526,296.0 мянган төгрөгийн нийт хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаа эрхэлсэн байна.

2025.II



Тайлант хугацаанд ҮМҮЧЭТХЭАЭ хуулийн этгээдүүдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 1.1 дахин, нийт хөрөнгийн хэмжээ болон хуримтлагдсан ашиг тус тус 1.2 дахин өссөн үзүүлэлттэй байна.

2024.II

2025.II

Нийт орлого

42,420,078.5 мянган төгрөг

Борлуулалтын орлого

42,011,050.8 мянган төгрөг

Нийт зардал

34,713,462.3 мянган төгрөг

Цэвэр ашиг 7,706,616.2 мянган төгрөг

Нийт орлого

34,623,266.7 мянган төгрөг

Борлуулалтын орлого

34,025,647.6 мянган төгрөг

Нийт зардал

29,901,798.9 мянган төгрөг

Цэвэр ашиг 4,721,467.8 мянган төгрөг

- ◆ Тайлант хугацаанд нэр бүхий 56 хуулийн этгээд нь 34,623,266.7 мянган төгрөгийн нийт орлоготой, 29,901,798.9 мянган төгрөгийн нийт зардалтайгаар үйл ажиллагаа эрхэлсэн байна.
- ◆ Мөн ҮМҮЧЭТХЭАЭ хуулийн этгээдүүд нь 4,721,467.8 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажилласан нь өмнөх оны мөн үеэс 1.6 дахин буурсан үзүүлэлт юм.
- ◆ ҮМҮЧЭТХЭАЭ хуулийн этгээдүүдийн нийт орлогын 98.3 хувийг борлуулалтын орлого эзэлж байна.

Үзүүлэлтүүд	2024.II		2025.II		Өөрчлөлт (+/-)	
	Дүн	Хувь	Дүн	Хувь	Хувь	
Борлуулалтын орлого (цэвэр)	42,011,050.8	99.0%	34,025,647.6	98.3%	-0.7%	
Түрээсийн орлого	313,849.1	0.7%	414,743.2	1.2%	0.5%	
Хүүний орлого	46,074.1	0.1%	36,469.7	0.1%	-	
Бусад орлого	47,629.2	0.1%	14,364.9	0.0%	-0.1%	
Гадаад валютын ханшийн зөрүүний олз	-	-	132,041.3	0.4%	0.4%	
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз	1,475.3	0.0%	-	-	-	
Нийт орлого	42,420,078.5	100.0%	34,623,266.7	100.0%	-	
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	21,843,155.7	62.9%	17,903,450.6	59.9%	-3.0%	
Борлуулалт, маркетингийн зардал	5,095,974.7	14.7%	3,935,488.7	13.2%	-1.5%	
Ерөнхий ба удирдлагын зардал	5,091,032.9	14.7%	6,094,781.3	20.4%	5.7%	
Санхүүгийн зардал	985,851.8	2.8%	976,809.17	3.3%	0.5%	
Бусад зардал	359,167.7	1.0%	353,060.1	1.2%	0.2%	
Татварын зардал	903,843.3	2.6%	576,814.0	1.9%	-0.6%	
Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	385,436.2	1.1%	-	-	-	
Бусад алдагдал	48,999.6	0.1%	-61,378.7	0.1%	-	
Нийт зардал	34,713,462.2	100.0%	29,901,798.9	100.0%	-	
Тайлант үеийн цэвэр ашиг	7,706,616.2		4,721,467.8		-	

Хяналт шалгалт

Тайлант хугацаанд нэр бүхий 17 хуулийн этгээдэд тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх мэдэгдэл, 38 хуулийн этгээдэд тайлангийн хариу хүргүүлсэн. Мөн нэр бүхий 2 иргэний ҮМҮЧЭТХЭАЭ-ийн үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон.

17



ТҮДГЭЛЗҮҮЛЭХ
МЭДЭГДЭЛ

38



ТАЙЛАНГИЙН
ХАРИУ

Бодлого зохицуулалт

- ◆ Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулсан “Монгол дархны уламжлал, шинэчлэл” анхдугаар чуулганыг зохион байгуулахад Хороо хамтран оролцлоо.
- ◆ Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн дагуу Стандарт, хэмжил зүйн газрын 2025.05.28-ны өдрийн тушаалаар батлагдсан үнэт металл, эрдэнийн чулуу, үнэт эдлэлийн салбарын үндэсний стандартын төсөл хэлэлцэх, дүгнэл гаргах зорилго бүхий Үнэт эдлэлийн стандартчилалын техникийн хороонд тус газраас нэр бүхий 2 албан хаагч ажиллаж байна.
- ◆ ОХУ-ын Санкт Петербург хотод зохион байгуулсан олон улсын эрдэнийн чулуу, үнэт эдлэлийн “JUNWEX SAINT PETERBURG 2025” үзэсгэлэнд Хорооны төлөөлөл оролцож, туршлага солилцлоо.

Сургалт

- ◆ Хорооны Өвөрхангай аймаг дахь орон нутгийн төлөөлөгчийн хүсэлтээр 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдөр тус аймагт үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдэд Хорооны 2020 оны 150 дугаар тогтоолоор баталсан журмын талаарх цахим сургалт зохион байгууллаа.
- ◆ “Тайлагнал болон Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэл” сэдэвт сургалтыг ҮМҮЧЭТХЭАЭ-ийн салбарт үйл ажиллагаа эрхэлж буй хуулийн этгээдүүдийн эрх бүхий албан тушаалтнуудад 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулсан.

Энэ оны эхний хагас жилийн байдлаар Хороонд үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй нэр 56 хуулийн этгээд, 492 иргэн бүртгэгдсэн байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн тоо 3-аар, иргэдийн тоо 39-өөр өссөн үзүүлэлт юм.

Тайлант хугацааны байдлаар ҮМҮЧЭТХЭАЭ 56 хуулийн этгээд нь 88 хувьцаа эзэмшигчийн 10,214,429.1 мянган төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаа эрхэлсэн байна. Хувь нийлүүлсэн хөрөнгийн 55.4 хувийг дотоодын хөрөнгө оруулалт эзэлж байгаа бол 44.6 хувийг гадаадын хөрөнгө оруулалт эзэлж байна.

Тайлант хугацаанд ҮМҮЧЭТХЭА эрхлэгчид 860.9 кг үнэт металлыг 123,838,511.5 мянган төгрөгөөр худалдан авч, 506.4кг үнэт металлыг 140,636,395.0 мянган төгрөгөөр худалдан борлуулсан байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад худалдан авсан үнэт металлын хэмжээ 1.1 дахин, худалдсан үнэт металлын хэмжээ 1.3 дахин буурсан үзүүлэлтэй байна.

ҮМҮЧЭТХЭА эрхлэгчид 2025 оны эхний хагас жилд 348.8 кг алтыг 121,615,848.9 мянган төгрөгөөр худалдан авсан нь өмнөх оны мөн үеэс худалдан авсан алтны хэмжээ 1.8 дахин, үнийн дүн 1.2 дахин буурсан бол 384.7 кг алтыг 137,546,181.3 мянган төгрөгөөр худалдан борлуулсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад худалдсан алтны хэмжээ 1.5 дахин, үнийн дүн 1.0 дахин буурсан үзүүлэлт юм.

Тайлант хугацаанд ҮМҮЧЭТХЭА эрхлэгчид нь нийт 269.3 кг мөнгийг 2,059,081.0 мянган төгрөгөөр худалдан авч, 121.4 кг мөнгийг 3,008,484.5 мянган төгрөгөөр худалдан борлуулсан бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад худалдан авсан мөнгөний хэмжээ 1.2 дахин буурсан бол худалдан борлуулсан мөнгөний хэмжээ 1.8 дахин өссөн үзүүлэлтэй байна.

Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн салбарын 2025 оны эхний хагас жилийн тайлангийн нэгтгэлд 56 хуулийн этгээд хамрагдсан бөгөөд 88 хувьцаа эзэмшигчийн 10,214,429.1 мянган төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй, 87,526,296.0 мянган төгрөгийн нийт хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаа эрхэлсэн байна.

Тайлант хугацаанд нэр бүхий 56 хуулийн этгээд нь 34,623,266.7 мянган төгрөгийн нийт орлоготой, 29,901,798.9 мянган төгрөгийн нийт зардалтайгаар үйл ажиллагаа эрхэлсэн байна.

Мөн ҮМҮЧЭТХЭАЭ хуулийн этгээдүүд нь 4,721,467.8 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажилласан нь өмнөх оны мөн үеэс 1.6 дахин буурсан үзүүлэлт юм.

ҮМҮЧЭТХЭАЭ хуулийн этгээдүүдийн нийт орлогын 98.3 хувийг борлуулалтын орлого эзэлж байна.

ОХУ-ын Санкт Петербург хотод зохион байгуулсан олон улсын эрдэнийн чулуу, үнэт эдлэлийн “JUNWEX SAINT PETERBURG 2025” үзэсгэлэнд Санхүүгийн зохицуулах хорооны төлөөлөл оролцлоо.

Монгол Улсын ерөнхийлөгчийн ивээл дор Монгол дархны уламжлал, шинэчлэл анхдугаар чуулган зохион байгуулагдлаа.